

КЫЗЫЛЫН ЧУЛУУН АГУЙН ХАНЫН ЗУРГУУД ДАХЬ
“ЖАТАКА”-ИЙН ҮЛГЭРҮҮД

Dao Ri Na

Түлхүүр үг: *Ханын зураг, Кызылын агуй, “Жатака”-ийн үлгэр, Будда бурхан, Жатака зураг*

Бид энэ өгүүлэлдээ Кызылын агуйн ханын зургуудад дүрслэгдсэн Будда бурханыг гэгээрэхээс өмнөх амьдралын тухай олон үлгэрийн өгүүлэмжүүдийг эртний ном судруудаас тайлан тайлбарлахыг зорьсон болно.

Хан гүрэн (НТӨ 206-220 он)-ий үеэс хойш одоогийн Хятадын Ганьсу муж, Шинжааны баруун бүс нутаг нь стратегийн чухал ач холбогдол бүхий худалдааны замын төвлөрөл байсан¹ бөгөөд Хан гүрний төр нуран унасны дараа, мөн Тан улсын үед өмнөд рүү нөлөө үзүүлснээр Кызылын хилийг хааж битүүмжилсэн гэж хэлж болно. Ингэснээр Кизил нь Хятадын соёлын нөлөөнд бүрэн уусаагүй бөгөөд иймээс тэндхийн соёлыг өвөрмөц хэвээр нь хадгалж ирсэн байна.

Эдгээр ханын зургууд нэг цаг үеийнх атлаа дүр дүрслэл, зургийн арга барил, утга агуулга, сэдэв зохиомжууд төсөөтэй хэдий ч адилгүй, дахин давтагдашгүй бүтээгдсэн нь бүтээсэн уран бүтээлчид нь хол нутгаас ирсэн, шашин соёл өөр хүмүүс байсан хийгээд өөрийн болон бусдынхаа уран бүтээлээс урам зориг авч өөрийн шашин, арга барилаар өөрчлөн урладаг байсан гэх зэрэг таамгууд байдаг. Мөн ханын зургуудыг нэгэн үеийн зураг урлал дээр дараа үеийнхэн давхарлан, баяжуулан, үргэлжлүүлж зурсан байх тохиолдол ч байна.

Кызылын ханын зургийн дүрслэл, зохиомжоос бурхны шашны агуулгыг шууд ойлгох боломжтой. Зургийн дүрслэлийн хэв маяг, тухайн үеийн шашны болон нутгийн соёлын онцлогоос үүдэн, үүнийг “Жатака зураг” гэж нэрлэх болсон байна. Ханын зурагт дүрслэгдсэн бүтээлүүд нь Бурханы шашны хатуу жаягаас гадна Азийн урлагийн өргөн хүрээний эх сурвалжуудыг илэрхийлж байдаг ч бид энэ удаад Бурханы шашинтай холбогдох дүр, өгүүлэмжүүдтэй холбогдох Жатака зургийн хэдэн жишээг сонгон авч, Жатака үлгэрийн өгүүлэмжтэй харьцуулан, зургийн утга санааг тайлан тайлбарлаж байна.

¹ Zhao Li, Zhao Li Ya, Wang Wei Dong, Li Xin Shu. Кызылын чулуун агуй дахь “Жатака” үлгэр. Шинжааны Кучагийн Чулуун агуй судлалын хүрээлэн. Шинжааны уран зураг, урлагийн гэрэл зургийн хэвлэл. 2007.

1. Махапрабаса хааны үлгэр



Кызылын 14-р агуйн зураг

Кызылын агуйгаас олдсон ханын зургуудад хэрэглэсэн өнгөний зохицол маш содон. Эдгээр гайхалтай будгийн бүх өнгө байгалийн эрдэс бодисуудаас бүрддэг бөгөөд Афганистанаас ирсэн өвөрмөц ашигт малтмалаас гаргаж авдаг байжээ. Дээрх заан хөлөглөсөн хааны зургийг Кызылын 14-р агуйн бөмбөгөр адарт дүрсэлсэн байдаг. Зургийн өгөгдсөн талбайд хөх болон цагаан цэнхэр өнгийг дэвсгэр болгон цагаан, цайвар ногоон өнгөөр модтой байгалийг дүрсэлж, цэнхэр өнгөөр голлон зохиомжилсон байна. Зургийн голд зааныг тод хөх өнгөөр, хааныг бүдэг өнгөөр дүрсэлснээр зааны дүрс зургийн төв болж байна.

Энэхүү заан хөлөглөсөн хааны зураг нь Махапрабаса хааны үлгэрийн өгүүлэмжтэй холбогдож байна. Үлгэрт өгүүлэхээр, “Нэгэн улсын хаан нь ихэд цэцэн, сэргэлэн, бүх эрдэмд гаргууд сурсан гэнэ. Түүнд хөрш хаант улсаас зааны тугал бэлэглэж, тугалыг тусгай сургагч өсгөн тэжээн сургажээ. Нэгэн өдөр хаан заанаа унаад зугаалахаар гарав. Гэнэт заан нуурын эрэгт бадам цэцгийн үндэс ухаж идэж буй

эмэгчин зааныг хараад, араас нь хөөн давхижээ. Хаан татан зогсоож дийлэхгүй, бүр модны мөчирт шавхуурдуулан нүүр ам нь шалбарч, хувцас нь урагдаад, улмаар модны мөчрөөс зүүгдэн үлдэж амь гарчээ. Ордондоо буцаад заан сургагчийг сайн сургасангүй хэмээн зэмлэхэд:


- Зааны биеийг би олон жил сайн сургасан, харин сэтгэлийг нь бурханаас өөр хэн ч захирч, сургаж дийлэхгүй байх гэжээ. Ингээд цэцэн хаан гүн утгыг ойлгон ухсанаар, бурханы шашинд шүтэх болсон гэнэ².

Зургийн тайлал.

Буддын шашинд цэнхэр өнгө нь мунхагаас гэтэлгэх, заан нь сүр хүч, эрдэм чадлыг бэлгэддэг. Заан эмээлэн хөлөглөсөн дүрслэл нь эртний Гандхарагийн урлагт ихэс дээдэс, язгууртны дүрслэлүүдэд элбэг тохиолддог. Толгойн титэм нь хаан хүн болохыг илтгэж байна. Харин титэм нь цэнхэр өнгөтэй байгаа нь ямар нэгэн агуулгагүй, зургийн гол зохиомж өнгийг бусад өнгөтэй уялдуулж буй дүрслэл бололтой. Үүнээс үлгэрийн гол сэдэв, агуулгыг хөх, цэнхэр өнгөөр илэрхийлжээ гэж таамаглаж болно. Энэ ташрамд дурдахад монголчуудын өнгөний бэлгэдлийг судалсан эрдэмтдийн судалгаанаас үзэхэд “...Хөх манхан тэнгэрийг хөх хониор тахиж... монгол айл болгон хотондоо, мал сүрэгтээ хөх, хөх халзан, хөхвөр хонь байлгахыг эрмэлзэж, мал хөрөнгийн сор дээж болгодог” (Дулам С. 2011:119). Дээрх ханын зургийн хөх цэнхэр өнгийн заан хөлөглөөд явж буй дүрслэл хийгээд хөх цэнхэр өнгийн орхимж намуруулсан дүрслэл нь мунхгийг гэтэлж, бурханы шашинд шүтэхээр одож буйн илэрхийлэл болжээ.

² Хятадын эртний “Цэцэн тэнэгийн шалтгааныг өгүүлэх I судар”-аас. 3-р боть 《贤愚经》卷三 нөгөө нэр нь 《贤愚因缘故事》 Умард Вэй улсын үеийн 沙门 (sha men буюу англи нэр: Shramana) цолт Хуй жүе 慧觉 (hui jue 554-606) орчуулан буулгажээ. Монгол хэлнээ “Үлгэрийн далай” гэх бөгөөд Лигдэн хутагт хааны үе 1629 онд тус үлгэрийг Ганжурын ботид оруулжээ. Ширээт Гүүш Цорж орчуулав хэмээсэн буй. Үндэстний хэвлэлийн хороо, Шинхуан номын дэлгүүрт тарааж үндэсний хэвлэх үйлдвэрт хэвлэв. 1988 оны 12 сард Бээжинд анх удаа хэвлэсэн.

2. Ах, дүү гурван амьтан



Кызылын 80-р агуйгаас олдсон ханын зураг.



Кызылын 17-р агуйгаас олдсон ханын зураг.

Үлгэрт өгүүлэхээр, “Эрт урьд ойд заан, сармагчин, тонишуул гурав нөхөрлөн, хамт амьдардаг байжээ. Тэд нэг өдөр хэн нь ах болохыг тогтоогоод, цаашид ахыгаа хүндлэж, дүүгээ асарч амьдрахаар болжээ. Тэгээд насны эрэмбээрээ заан нуруундаа сармагчинг суулгаж, сармагчин толгой дээрээ тонишуулыг суулгаад, ахан дүүс биесээ хэрхэн хүндэлж байгааг хүмүүст харуулж, зааж өгөхөөр хот руу явж, хотын гудамжаар үлгэрлэн үзүүлжээ”³.

Зургийн тайлал. Зургийг цайвар ногоон суурь дээр цагаан, хүрэн, хар өнгүүдээр бусад дүрслэлүүдийг тодотгон босоо зохиомжтой зуржээ. Зургийн дүрслэл, зохиомжоос дээрх үлгэрийн агуулгыг шууд ойлгох боломжтой.

3. Ачит зааны үлгэр

Энэ зургийн утга нь заан хүмүүсийн амийг аврахын тулд өөрийн амиа зольсон тухай үлгэрийн өгүүлэмжтэй холбогдоно.

Үлгэрт өгүүлэхээр, “Заан их элстэй ууланд явж байтал хэсэг хүмүүстэй тааралдаад юу хийж буйг нь асуутал тэд цөлөгдсөн хүмүүс байв. Ус, хоол байхгүй энэ нутагт тэдний нэлээд нь үхсэн байв. Заан дотроо энэ хүмүүст хэрхэн туслах тухай боджээ. Тэгээд:

- Та нар уулын бэлд буу, тэнд бадма цэцгийн нуур бий. Нуурын хажууд саяхан үхсэн заан байгаа. Түүний махыг идэж, гэдсэнд нь нуурын уснаас нөөцлөөд явбал та бүхэн энэ их элснээс эсэн мэнд гарч чадна гэжээ.

Хүмүүс заанд машид талархан уулын бэл рүү буухаар явсны дараа заан уулнаас доош үсэрч үхжээ. Хүмүүс нуурын тунгалаг усаар ундаалж, үхсэн зааны хажууд ирээд, саяхан ярицсан заан болохыг таниад ихэд гашиуудав. Тэд зааны махыг идэхээс татгалзтал нэг нь:

-Хэрэв бид зааны зааснаар хийхгүй бол түүний амь дэмий үрэгдэнэ гээд махыг идэж, аяны хүнс бэлтгээд, арьсаар нь тулам хийж ус нөөцлөн явсаар их элснээс эсэн мэнд гарцаажээ”⁴.

³ Хятадын эртний “jing lu yi xiang” судрын 47-р боть. 《经律异相》卷四十七 Умард Сүн улсын үед Bao chang (宝唱) хувраг орчуулан эмхэтгэжээ. Нийт 50 боть бөгөөд түүнээс гарчиг нь 5 боть болой. Шанхайн эртний бичгийн хэвлэлийн хороо, 1888 оны 10 сарын 1.

⁴ Бурханы судрын үлгэрийн түүвэр. Luo bing fen (罗秉芬) орчуулан эмхтгэсэн. Лхас хотын Төвөдийн ардын хэвлэлийн хороо, 1999.

Зургийн тайлал.

Босоо зохиомжтой ч зургийн голд гурвалжин хар суурь дотор гол дүрслэлүүдийг төв болгожээ. Гол дүрслэл нь мөн цэнхэр өнгөтэй заан байгаа нь хүмүүсийг ухааруулах, гэгээрүүлэх гэсэн үлгэрийн агуулгыг бүрэн илэрхийлж байна. Жатакийн үлгэр домогт цэнхэр өнгөт заан нь ухаарал, гэгээрлийн бэлгэдэл болж элбэг дүрслэгддэг байна. Зураг дээр цайвар, гэгээлэг өнгийг суурь болгосон атлаа голд нь хар бараан гурвалжин дүрс оруулж ирсэн нь маш сонирхолтой шийдэл байна. Хар өнгө нь энэ хэсгийн бараан, гунигтай өгүүлэмжийг буюу заан үхсэн санааг илэрхийлж байна. Монголчуудын өнгө ба дүрсийн бэлгэдлийг судалсан эрдэмтдийн судалгаанаас үзэхэд “Хар өнгө бол монгол утга соёлд домог зүй, бөө мөргөлийн зүүн зүгийн дөчин дөрвөн тэнгэрийн өнгө зүс, түүнтэй холбоотой муу үйлийн өнгө болох учир буй” бөгөөд “. . . Монгол үлгэр туульсад гардаг муу зүгийн мангас дайсадыг хийж дардаг жаран алд жандмань /гурвалжин/ хар там болон монгол бөө мөргөлд муу зүгийн ад хорлолыг хийж түгждэг гурвалжин хар нүх нь цөм нэгэн ижил утгатай дүрсүүд болдог” (Дулам, 2011б, 39) нь тус ханын зургийн өнгө дүрслэлтэй нийцэж байна. Ханын зургуудад үхэл болон үхлийн дараах байдал, өөр ертөнц, тэр дундаа тамыг хараар дүрсэлдэг нь буддын шашны болон Гандхарагийн урлагийн онцлог юм. Жатака зурагт эдгээр соёл, урлагийн нөлөө их байгаа нь үүгээр дахин батлагдана.

4. Энэрэнгүй хүүгийн үлгэр



Кызылын 114-р агуйгаас олдсон ханын зураг.

Үлгэрт өгүүлэхээр, “Эрт цагт замбуу тивд нэгэн хаант улс байжээ. Хааны түшмэл хаанаа алж, төрийг эргүүлжээ. Ханхүү хатан болон 7 настай хүүгийн хамтаар зугтаж явахдаа өлсөж ундаасан туйлдав. Ханхүү хатнаа алаад, махаар хүүтэйгээ хоёул амь зогоохоор шийдээд, хутга аван хатны араас явахад хүү нь хараад эцгээ зогсоожээ. Эцэгтээ:

- Ээж та хоёр өдөр бүр миний махнаас бага багаар идэж, амь зогоо, харин дуусах үед нь багахан хэсгийг өглөгт үлдээгээрэй гэж захив.

Ханхүү, хатан хоёул хүүгийн махыг идэж дуусахдаа толгойг нь үлдээжээ. Нэгэн өдөр Сакра тэнгэр гуйлгачны дүрээр ирэхэд хүү нүд хэлээ өгчээ. Дараа амьтдын дүрээр ирэхэд хүү мөн үлдсэн хэсгүүдээ өгчээ. Ингээд тэнгэр өөрийн дүрдээ хувирч, хүүгээс яагаад ингэсэн учрыг лавлахад хүү харамсахгүй байгаагаа, мөн туйлын хүсэл нь энэ ертөнцийн бүх амьтдыг зовлонгоос гэтэлгэх явдал гэдгээ хэлжээ. Үүнийг сонсоод Сакра тэнгэр хүүгийн махан биеийг буцаан эдгээж өгчээ”.

Зургийн тайлал:

Зураг бүхэлдээ хар суурьтай байгаа нь өгүүлэмжийн маш гүн гүнзгий, хүнд хэцүү агуулгыг илтгэж байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн толгойн гоёл, хувцас, чимэглэлээс язгууртан, ихэс дээдэс болохыг таньж болно. Харин хүү чармай шалдан дүрслэгдсэн нь үхсэний дараа Сакра тэнгэр түүний махан биеийг эргүүлэн өгч, дахин амьдруулсаны илэрхийлэл юм. Үүнийг Буддын шашны хүн нүцгэн төрөөд, нүцгэн буцна гэсэн сургаальтай

ч холбож үзэж болно. Ханхүү хатнаа зольж, хүү болон өөрийгөө аврах гэсэн, мөн хүү эцэг эхийнхээ төлөө өөрийгөө зольж байгаагаас хүн төрөлхтөн балчир ахуйдаа машид гэгээн сэтгэлтэй байж, амьдрал хэмээх зовлонд орооцолдон мунхардгийг өгүүлсэн болов уу.

5. Бич, барлаг хоёрын үлгэр



Кызылын 17-р агуйгаас олдсон ханын зураг.

Үлгэрт өгүүлэхээр “Нэгэн цэцгэн сүлжээс зүүсэн барлаг хааны зарлигаар амар модны жимс түүхээр уул руу явжээ. Тэр замаа олохгүй төөрч, эгц уул руу авирч байгаад унажээ. Бич түүн дээр ирээд учрыг лавлахад барлаг амар модны жимс түүж чадахгүй буцвал хаанд шийтгүүлж магадгүй тухайгаа яриу. Үүнийг бич сонсоод, хадан дээрх мод руу авирч, жимс түүж өгчээ. Барлаг жимснээс идэж, гэдэс гараад, үлдсэнийг аван ордон руу буцаж явах замдаа дахиж өлсөж, ядрах тул жимсээ идэж болохгүй, тиймээс бичийг алаад хүнс хийе гэж бодож. Бич ядраад унтсаны дараа ирээд чулуугаар цохиж алав. Тэнгэрийн сахиус үүнийг олж хараад түүн дээр ирээд, тусыг усаар хариулсан тул нүглээ үүрнэ гэдгийг хэлжээ”⁵.

Зургийн тайлал:

Зургийн суурь өнгө цайвар ногоон боловч гол нь ромбо хэлбэрийн цагаан дэвсгэр дотор сармагчинг бүдэг өнгөөр, барлагийг тод өнгөөр дүрсэлсэн нь зургийн төв дүрслэлээ илүү тод харуулж буй хэлбэр юм. Цайвар суурь дээр

бор гөрөөс, улбар үнэг, цэнхэр шувуу зэрэг ойн бусад амьтад болон тэнгэрийн сахиустай холбоотой дүрслэлүүдийг бор, хөх, хар өнгүүдээр тодотгон дүрсэлсэн байна.

Зургийн дээд болон дунд хэсэг нэг өгүүлэмжийг багтаасан, барлаг сармагчинг чулуугаар цохиж буй дүрслэлтэй, доод хэсэгт тэнгэрийн сахиусууд энэ байдлыг харж буйг хоёр тусад нь зохиомжлон харуулсан. Тэнгэрийн сахиусуудын хажууд тод цэнхэр мод, тод ногоон, цэнхэр, шар өнгөтэй солонго шиг дугуйран давхарласан дүрсүүдээр буддын шашны гэрлүүдийг буюу энэ хэсэг нь тэнгэрийн сахиусуудын өгүүлэмжит орон зай болохыг дүрсэлсэн байна.

Мод түшин унтаж буй сармагчинг цайвар бор өнгөөр дүрсэлсэн нь түүнийг гэгээн, өгөөмөр сэтгэлт болохыг, харин барлагийг хар бараан өнгөөр дүрсэлсэн нь түүний сэтгэл харанхуй болохыг илтгэж буй. Тэнгэрийн сахиусын нэг нь цайвар, нөгөө нь бараан өнгөтэй байгаа нь цагаан, хар сэтгэл орчлонд зэрэгцэн оршдог гэсэн илэрхийлэл санаа болно. Мөн цайвар өнгөөр дүрсэлсэн тэнгэрийн сахиусын арын гэрэл тод цэнхэр өнгөтэй байгаа нь тэр сахиусын хэлсэнчлэн “Үйлийн үр эргэдэг” гэсэн санааг ухааруулах зорилготой өгүүлэмж болно.

⁵ Vinaya-ын хуврагийн үйлийн үүсгэх, түрэгтгэх Qian longda zang jing (乾隆大藏经) сударт байдаг үлгэр.

6. Эх бугын үлгэр



Кызылын 224-р агуйгаас олдсон ханын зураг.

Үлгэрт өгүүлэхээр, “Хоёр нялх зулзагатай буга ойд анчны хавханд оржээ. Анчин ирээд алах гэхэд буга:

-Хоёр янзага балчир, өөрсдөө идэш олж мэдэхгүй, цааш амьдарч чадахгүй, хэрэв зөвшөөрвөл очиж хооллоод, тэдэндээ мэдэхгүй, чадахгүйг нь зааж сургаад, буцаад ирье гэж гүйжээ.

Анчин буганд:

-Хүмүүс ч хэлсэндээ хүрдэггүй байтал амьтанд итгэхгүй гэсэн ч бугыг явуулжээ.

Эх буга янзагануудаа хооллож, хүнс тэжээл бэлдээд, зааж сургачихаад амласан ёсоороо анчин дээр буцаж ирсэнд анчин түүнийг тавиад явуулжээ. Анчин хаандаа очоод болсон явдлыг ярьж, хаан ихэд уяран, түүнээс хойш буга агнахыг хориглов гэнэ”⁶.

Зургийн тайлал:

Тус зурагт тод цэнхэр суурь дээр том цагаан навч хэлбэрийн дүрс дотор янзагаа хөхүүлж буй эх бугыг төв болгон зохиомжилжээ. Зургийн

дунд хэсгээс доошоо дугуйрсан хэлбэртэй бор өнгийн моддыг дүрсэлсэн бөгөөд мод ногоон навчтай, цэнхэр цэцэгтэй байгаа нь өнгөний зохицлыг харуулсан уран сайхны дүрслэл байна. Модны наана зүүн, баруун доод хэсэгт хоёр хүний дүрсэлсэн нь анчин болон хаан юм. Тэд эсрэг зүг рүү харсан нь хоёр өөр цаг хугацаанд, хоёр өөр газарт байж, түүнийгээ дараа нь ярилцсаныг илтгэж буй болов уу. Баруун талын хүний дүрсийн толгойн хэсэгт нэлээд эвдэрч муудсан байгаа ч мөрөөс дээш цэнхэр өнгө өргөн тавигдсан, хүзүүний доод хэсэгт мөн цэнхэр өнгө харагдаж буй нь толгойдоо цэнхэр гэрэлтэй тэнгэрийн сахиусын дүр болов уу гэсэн таамгийг төрүүлнэ.

Зохиогч буга гэж орчуулсан ч буддын шашны сургаальд гардаг “Бодь гөрөөс” -ийг цэнхэр өнгөөр дүрсэлсэн нь мөн уг бүтээлээр дамжуулж ухаарлыг хүртээх гэсэн агуулгатай. Зургийн суурь өнгө цэнхэр байгаа нь шашны агуулга, эсвэл тэнгэрийг төлөөлөх зургийн дүрслэл байх гэж таамаглаж байна.

Бид энэ өгүүлэлдээ Кызылын агуйн ханын зургуудад дүрслэгдсэн Будда бурханыг гэгээрэхээс өмнөх амьдралын тухай олон үлгэрийн өгүүлэмжүүдээс сонгон судлаад дараах дүгнэлтийг хийж байна.

1. Кызылын агуйгаас олдсон ханын зургуудад хэрэглэсэн өнгөний зохицол нь хөх, цэнхэр голлох бөгөөд өгөгдсөн талбайд цайвар цэнхэр өнгийг дэвсгэр болгож, хөх цэнхэр өнгөт заан, бодь гөрөөс зэрэг дүр нь ухаарал, гэгээрлийн бэлгэдэл болж, Буддын шашны Жатака үлгэрийн утга санааг илтгэж байна.

2. Тус ханын зургуудад бурхан сахиулсны хажууд тод цэнхэр мод, тод ногоон, цэнхэр, шар өнгийн солонго шиг дугуйран давхарласан дүрсээр буддын шашны гэрэл, тэнгэрийн сахиусуудын өгүүлэмжит орон зай болохыг дүрсэлдэг илтгэдэг байна.

⁶ Хятадын эртний “Трипитака” буюу “jing lu yi xiang” судрын 4-р боть. 《经律异相》卷四 Умард Сүн улсын үе Bao chang(宝唱) хувраг орчуулан эмхтгэжээ. Нийт 50 боть бөгөөд түүнээс арчиг нь 5 боть болой. Шанхайн эртний бичгийн хэвлэлийн хороо, 1888 оны 10 сарын 1.

3. Тус ханын зургуудад үхэл хийгээд “Үйлийн үр эргэдэг” гэсэн санааг илэрхийлэхдээ хар өнгийн гурвалжин дүрсийг оруулж ирсэн байдал нь хар өнгөөр өөр ертөнц, тэр дундаа тамыг дүрсэлдэг Гандхарагийн урлагийн онцлогийг харуулж, Буддын шашны соёл, урлагийн нөлөө их байгааг батлаж байна.

JAKAC’S FAIRY TALES IN THE WALLS OF THE KIZIL’S STONE CAVE

7 km southeast of the village of Bai Cheng, the village of Kizil ming Ōy stone cave, this cave is located on Mount Taga. In the south, the River Moza will flow. God is the first station to be passed to China. The 3-rd century is the most ancient cave in the country, civic arts have many aspects of the ancient Indian landscape and the Greek culture the Buddha studied the illustrations of life before the enlightenment of the goddess in the wall, the ancient books interpret the scriptures.